



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/67

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдсэн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар Ховд хотын нийтийн эзэмшлийн зам дагуу байгаа ургалт нь зогссон улиас модонд тайралт хийх ажилд зориулан 3 895 000 төгрөгийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 3 895 000 төгрөг /гурван сая найман зуун ерэн таван мянга/-ийг аймгийн байгаль хамгаалах сангийн 2.1-д тусгагдсан “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого зорилтыг хэрэгжүүлэх” арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал ханган, мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө авч ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга /Б.Алтанбадралт/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/67 Ch

02 0599

Аймгийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 08-ны өдрийн
А/67 дугаар захирамжийн хавсралт

“Ховд хотын нийтийн эзэмшлийн зам дагуу ургалт нь зогссон улиас
модонд тайралт хийх ажил”-ын зардлын жагсаалт

№	Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт дүн /мян.төг/	Тайлбар
1	Дружба хөрөө худалдан авах	ширхэг	4	250 000	1 000 000	Улиас модонд тайралт хийх
2	Шатахуун	литр	157,1	2100	330 000	Дружба хөрөөнд хийх бензин
3	Сандал хийх	ширхэг	20	49 500	990 000	Тайралт хийсэн модоор нийтийн эзэмшлийн зам, талбайд сандал хийх
4	Хоол хүнс	хүн/өдөр	105	15 000	1 575 000	Ажилчдын өдрийн хоол
Дүн					3 895 000	

oooOooo